



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/109/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	3
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	4
3.4. Материаллаг байдал.....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт.....	9
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	9
Аудитын зөвлөмж.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	10
4. Менежментийн захидал.....	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	12

1.Хараат бус аудиторын дүгнэлт

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Л.ЭРДЭНЭБАТ ТАНАА

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.17. № 40
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

ДОА-2021/109/СТА-ТШЗ 3

011021207



ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠠᠭ
ᠰᠢᠵᠡᠭᠡᠨ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋᠋᠋᠋᠋ ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋᠋᠋᠋᠋
ᠰᠢᠶᠢᠳᠦ᠋᠋᠋᠋᠋

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	98222932.90	99767577.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	250800.00	167500.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	250800.00	167500.00
3121	Төгрөг	250800.00	167500.00
31211	Төрийн сангийн харилцах	250800.00	167500.00
33	АВЛАГА	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	97972132.90	99600077.90
351	Түүхий эд материал	7605262.00	8216862.00
35110	Тусгай зориулалттай материал	7605262.00	8216862.00
354	Хангамжийн материал	55396870.90	60963215.90
35410	Бичиг хэргийн материал	61800.00	69000.00
35420	Аж ахуйн материал	45605773.50	50197511.90
35440	Түлш, шатах тослох материал	642400.00	855000.00
35450	Барилгын засварын материал	4807704.40	5901500.00
35460	Хүнсний материал	4279193.00	3940204.00
35470	Бусад хангамжийн материал	0.00	0.00
35600	Мал амьтад	34970000.00	30420000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1140597779.45	1244098121.43
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1140597779.45	1244098121.43
392	Биет хөрөнгө	1070824830.83	1075108377.75
39201	Барилга, байгууламж, орон сууц	1070193316.23	1070193316.23
39202	Хуримтлагдсан элэгдэл	-53623606.20	-71947206.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84340000.00	114310000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-83740000.00	-86005000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	123401053.20	116535553.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95235013.78	-90125800.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37068638.00	37068638.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16237380.62	-19578946.14
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	4657824.00	4657824.00
393	Биет бус хөрөнгө	69772948.62	168989743.68
39301	Програм хангамж	6417692.31	6417692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5394743.69	-6177948.63
39303	Бусад биет бус хөрөнгө	68750000.00	168750000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1238820712.35	1343865699.33
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	250800.00	167500.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	250800.00	167500.00
413	Өглөг	250800.00	167500.00
4136	Бусад өглөг	250800.00	167500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	250800.00	167500.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1238569912.35	1343698199.33
51	Засгийн газрын хувь оролцоо	1238569912.35	1343698199.33
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	191442242.90	291442242.90
51101	Өмч: - төрийн	191442242.90	291442242.90
512	Хуримтлагдсан үр дүн	721302162.20	726430449.18
51210	Өмнөх үеийн үр дүн	721302162.20	721302162.20
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	5128286.98
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	325825507.25	325825507.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1238820712.35	1,343,865,699.33

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	605047592.30	675130097.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34245992.30	57451697.50
120	Нийтлэг татварын бус орлого	34245992.30	57451697.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34245992.30	57451697.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжилт	3320300.00	2070690.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	30925692.30	55381007.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	570801600.00	617678400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	570801600.00	616678400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570801600.00	616678400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	1000000.00
131103	ЗГНХ,ЗДНХ,Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1000000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	642614209.01	670001810.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	642614209.01	670001810.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	635062165.45	664919591.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430349311.24	471666644.09
210101	Үндсэн цалин	283979657.28	306569715.78
210102	Нэмэгдэл	125830318.96	144212411.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	18277000.00
210104	Урамшуулал	20539335.00	2607517.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9024962.13	9729241.07
210201	Тэтгэврийн даатгал	0.00	245815.54
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	28919.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	23135.58
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	5783.88
210205	Эрүүл мэндийн даатгал	9024962.13	9425586.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34292700.00	41295881.96
210301	Гэрэл, цахилгаан	11821799.00	15688852.08
210302	Түлш, халаалт	10074146.00	9819240.78
210303	Цэвэр, бохир ус	12396755.00	15787789.10
2104	Хангамж, бараа материалын зардал	31837316.53	27129736.20
210401	Бичиг хэрэг	3343870.00	2979800.00
210402	Тээвэр, шатахуун	15914700.00	13129400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2962888.00	3335198.20
210404	Ном, хэвлэл	162420.00	100600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	640100.00	734000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3825468.00	2322608.00
210408	Бараа материал актисны зардал	4987870.53	4528130.00
2105	Нормативт зардал	42055523.70	42978944.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1073219.00	916042.00
210502	Хоол, хүнс	36872565.00	40156739.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4109739.70	1906163.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31635003.00	22536876.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	92600.00	181700.00
210604	Урсгал засвар	31542403.00	22355176.00
2107	Томилголт, зочны зардал	4948600.00	692000.00
210702	Дотоод албан томилолт	4948600.00	692000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3799100.00	3242300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2036000.00	1430600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.00	360000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180100.00	197600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1000000.00	944100.00
210807	Газрын төлбөр	222000.00	222000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	47119648.85	45647968.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5422690.00	10843810.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500000.00	500000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	41196958.85	34304158.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7552043.56	5082218.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	396800.00	403200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	396800.00	403200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6359653.00	4660000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6359653.00	4660000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	795590.56	19018.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	795590.56	19018.68
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-37566616.71	5128286.98
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-37566616.71	5128286.98

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	584661309.44	633179788.62
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13875300.00	15501388.62
120	Нийтлэг татварын бус орлого	13875300.00	15501388.62
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13875300.00	15501388.62
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13875300.00	15501388.62
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	570786009.44	617678400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	570006009.44	616678400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	570006009.44	616678400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	780000.00	1000000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	1000000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	780000.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	584410509.44	630263088.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	584410509.44	630263088.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	580934056.44	629340869.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430349311.24	471666644.09
210101	Үндсэн цалин	283979657.28	306569715.78
210102	Нэмэгдэл	125830318.96	144212411.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	18277000.00
210104	Урамшуулал	20539335.00	2607517.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9024676.20	9729241.07
210201	Тэтгэврийн даатгал	0.00	245815.54
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	28919.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	23135.58
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	5783.88
210205	Эрүүл мэндийн даатгал	9024676.20	9425586.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34292700.00	41295881.96
210301	Гэрэл, цахилгаан	11821799.00	15688852.08
210302	Түлш, халаалт	10074146.00	9819240.78
210303	Цэвэр, бохир ус	12396755.00	15787789.10
2104	Хангамж, бараа материалын зардал	27593613.00	22664426.20
210401	Бичиг хэрэг	3282970.00	2987000.00
210402	Тээвэр, шатахуун	15780000.00	12803000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2955838.00	3222248.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	640100.00	734000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4934705.00	2918178.00
2105	Нормативт зардал	35499166.00	39803792.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1073219.00	886042.00
210502	Хоол, хүнс	34425947.00	38917750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27800000.00	25268776.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1771997.00	598400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	92600.00	181700.00
210604	Урсгал засвар	25935403.00	24488676.00
2107	Томилголт, зочны зардал	4948600.00	692000.00
210702	Дотоод албан томилголт	4948600.00	692000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6638300.00	12321298.62
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4875200.00	10509598.62
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240000.00	360000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	180100.00	197600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1000000.00	944100.00
210807	Газрын төлбөр	222000.00	222000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4787690.00	5898810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4287690.00	5398810.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500000.00	500000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3476453.00	922218.68
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	396800.00	403200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	396800.00	403200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3079653.00	500000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3079653.00	500000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	19018.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	19018.68
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	250800.00	2916700.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	0.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	0.00	3000000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	3000000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	3000000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	3000000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	0.00	-3000000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	250800.00	-83300.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	250800.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	250800.00	167500.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,442,242.90	325,825,507.25	758,088,778.91		1,275,356,529.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл					0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-36,786,616.71		-36,786,616.71
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,442,242.90	325,825,507.25	721,302,162.20	0.00	1,238,569,912.35
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	191,442,242.00	325,825,507.25	721,302,162.20	0.00	1,238,569,912.35
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	100,000,000.00	0.00	0.00		100,000,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	291,442,242.90	325,825,507.25	721,302,162.20	0.00	1,338,569,912.35
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			5,128,286.98		5,128,286.98
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	291,442,242.90	325,825,507.25	726,430,449.18	0.00	1,343,698,199.33

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	623178400.00	623165071.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	623178400.00	623165071.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	622275100.00	622261871.32
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	471666700.00	471666644.09
210101	Үндсэн цалин	294154100.00	306569715.78
210102	Нэмэгдэл	165639400.00	144212411.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9633700.00	18277000.00
210104	Урамшуулал	2239500.00	2607517.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	9729300.00	9729241.07
210201	Тэтгэврийн даатгал	0.00	245815.54
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	28919.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	23135.58
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	5783.88
210205	Эрүүл мэндийн даатгал	9729300.00	9425586.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41295900.00	41295881.96
210301	Гэрэл, цахилгаан	12949300.00	15688852.08
210302	Тулш, халаалт	12608500.00	9819240.78
210303	Цэвэр, бохир ус	15738100.00	15787789.10
2104	Хангамж, бараа материалын зардал	22664500.00	22664426.20
210401	Бичиг хэрэг	2997100.00	2987000.00
210402	Тээвэр, шатахуун	12803300.00	12803000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3167500.00	3222248.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	740000.00	734000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2956600.00	2918178.00
2105	Нормативт зардал	39803900.00	39803792.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	886100.00	886042.00
210502	Хоол, хүнс	38917800.00	38917750.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28280500.00	28268776.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3600000.00	3598400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	182000.00	181700.00
210604	Урсгал засвар	24498500.00	24488676.00
2107	Томилолт, зочны зардал	692000.00	692000.00
210702	Дотоод албан томилолт	692000.00	692000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3242300.00	3242300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1430600.00	1430600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360000.00	360000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	197600.00	197600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88000.00	88000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	944100.00	944100.00
210807	Газрын төлбөр	222000.00	222000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4900000.00	4898810.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4400000.00	4398810.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500000.00	500000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	903300.00	903200.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	403300.00	403200.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	403300.00	403200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500000.00	500000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500000.00	500000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	623178400.00	623165071.32
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	616678400.00	616659381.32
131001	Улсын төсвөөс санхүүжих	616678400.00	616659381.32
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6500000.00	6505690.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6500000.00	6505690.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00



3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг дарга, дэд хурандаа Л.Эрдэнэбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 1/43 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Шүүхийн шийдвэр биелүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2020 онд Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 642,614.2 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 12,852.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 670,001.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 13,400.0 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 105,044.9 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан биет бус үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0	-
Авлага	-	0	-
Урьдчилгаа	-	0	-
Бараа материал	97,972.10	99,600.00	1,627.90
Үндсэн хөрөнгө	1,140,597.70	1,244,098.10	103,500.40
Хуримтлагдсан элэгдэл	254,230.70	273,834.90	19,604.20
Нийт хөрөнгө	1,238,820.70	1,343,865.70	105,045.00
Өр төлбөр	250.80	167.5	(83.30)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,238,569.90	1,343,698.20	105,128.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,238,820.70	1,343,865.70	105,045.00

Бараа материалын дансны үлдэгдэл 99,600.0 мянган төгрөг болж 1,627.9 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,244,098.1 мянган төгрөг болж 103,500.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд автомашин болон газар орлогодож авсан дүнгээр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,343,698.2 мянган төгрөг болж 105,128.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэмэгдсэн хөрөнгийн дүнгээр өссөн байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 69,302.5 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 69,302.5 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт, Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 27,387.6 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 623,178.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 623,178.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 623,165.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 623,165.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 616,659.4 мянган төгрөгийг улсын төсвөөс 6,505.7 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 616,659.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 6,505.7 мянган төгрөг, нийт 623,165.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 623,165.0 мянган төгрөгийг зарцуулж 19.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 633,179.8 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Засаг даргаас нэмэлт санхүүжилтийн дансанд 1,000.0 мянган төгрөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал шилжүүлсэн. Уг зардлыг сургалт, сурталчилгааны ажилд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих 149 мэдээллээс хугацаа хоцроон байршуулсан мэдээлэл байхгүй байна. Гэхдээ төсвийн гүйцэтгэлийн улирлын мэдээний хэмнэлт, хэтрэлтийн шалтгаан тайлбарыг бичиж оруулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5,511.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	5,551.0	2	5,551.0	-	-	-
Нийт дүн	2	5,551.0	2	5,551.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 13,016.7 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж, 2 албан шаардлага, 1 төлбөрийн акт хүргүүлсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил байхгүй

Аудитаар 12,615.3 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 10,431.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2,184.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Тайлант оны нийт худалдан авалтыг татварын цахим е-баримт системийн бүртгэлээр тулгахад 5,827.2 мянган төгрөгийн худалдан авалтаар буюу 4.8 хувь нь бүртгэлгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 “Анхан шатны баримтад Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.”, Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан заавар, маягтай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд шилэн дансны цахим сайтад төсвийн гүйцэтгэлийн мэдээнд нийт 4,603.8 мянган төгрөгийн хэмнэлтийн тайлбар шалтгааныг бичиж оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6 “төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр” гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

3. Албан хаагчдад үндсэн цалингийн хувиар бууруулах сахилгын шийтгэл оногдуулахдаа цалингийн нэмэгдлүүдийг бууруулж тооцоогүйн улмаас 2184.3 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48.1.2 дахь заалт “албан тушаалын цалингийн хэмжээг ... 20 хүртэл хувиар бууруулах;”, ЗГ-ын 2011 оны 189 дүгээр тогтоол, 2017 оны 285 дугаар тогтоолтой нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

Аудитын зөвлөмж

Аудитаар дуудлагын автомашины өдөрт заасан км-ээс хэтрүүлэхгүй хэрэглэх талаар зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.



3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Бараа материалын зардлыг анхааралдаа авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Шилэн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Аудитаар байгууллагын дуудлагын автомашин 45-59 ДОР КИА Карнивал загварын автомашиныг ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасан өдөрт явах километрээс илүү ашиглаж байгаа тохиолдол илэрсэн.
- 1.2. Эрсдэл: Автомашиныг хувийн хэрэгцээнд ашиглах,
- 1.3. Өгсөн зөвлөмж: ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолд заасан “дуудлагын автомашин өдөрт 40км-ээс хэтрүүлэхгүй байхаар хэрэглэж байхаар тогтоосугай” гэснийг хэрэгжүүлж ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Тайлант оны сүүлд нэмж Ниссан Патрол маркын автомашинтай болсон тул ЗГ-ын тогтоолоос хэтрүүлэхгүй ашиглана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДОА-2021/109/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорнод аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансанд байршуулсан мэдээллээс үзэхэд төсвийн гүйцэтгэлийн хэмнэлтийн шалтгаан	4,603.8	Албан шаардлага	Дарга, дэд хурандаа, Ахлах	Л.Эрдэнэбат, Х.Борчулуун



	тайлбарыг бичиж байршуулдаггүй байна.			нягтлан бодогч, хошууч	
2	Байгууллагын 45-59 ДОР дугаартай дуудлагын автомашиныг ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолоор тогтоосон өдөрт явах километрээс хэтрүүлэн хэрэглэсэн.	401.4	Зөвлөмж	Дарга, дэд хурандаа, Ахлах нягтлан бодогч, хошууч	Л.Эрдэнэбат, Х.Борчулуун
3	Тайлант оны нийт худалдан авалтыг татварын цахим е-баримт системийн бүртгэлээр тулгахад 5.8л сая төгрөгийн худалдан авалтаар зөрүүтэй байна. Энэ нийт худалдан авалтын 4.8 хувийг эзэлж байна. Энэ нь Сангийн Сайдын 2017 оны 347 дугаар тушаалтай нийцэхгүй байна.	5827.2	Албан шаардлага	Дарга, дэд хурандаа, Ахлах нягтлан бодогч, хошууч	Л.Эрдэнэбат, Х.Борчулуун
4	Шалгагдагч байгууллага албан хаагчдад сахилгын шийтгэл оногдуулахдаа үндсэн цалинг бууруулахгүйгээр цалингийн нэмэгдлүүдийг тооцож олгогдсон байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 48.1.2 дахь заалттай нийцэхгүй байна.	2184.3	Төлбөрийн акт	Дарга, дэд хурандаа, Ахлах нягтлан бодогч, хошууч	Л.Эрдэнэбат, Х.Борчулуун
ДҮН		13,016.7			